

Үнэт цаасыг бүртгэлээс хасах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.7, Компанийн тухай хуулийн 34 дүгээр зүйл, “Сүлжээ” ХК-ийн хувь нийлүүлэгчдийн 2007 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн ээлжит бус хурлын тогтоолыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ НЬ:

1.Компанийн хэлбэрийг хязгаарлагдмал хариуцлагатай компани болгон өөрчлөхөөр шийдвэрлэсэн “Сүлжээ” ХК-ийн нийтэд санал болгон гаргасан нийт 569518 ширхэг хувьцааг үнэт цаасны бүртгэлээс хасахыг Үнэт цаасны газар (Х.Бум-Эрдэнэ), Хөрөнгийн биржийн жагсаалтаас хасахыг “МХБ” ХК (Р.Содхүү), Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжаас хасахыг “ҮЦТТГХТ” ХХК (Т.Гандулам)-д тус тус зөвшөөрсүгэй.

2.Компанийн зохион байгуулалтын хэлбэрийг өөрчилж байгаатай холбогдуулан өөрийн эзэмшиж буй хувьцааг эргүүлэн худалдан авахыг компаниас шаардаагүй хувьцаа эзэмшигчдийн өмчлөл дэх хувьцааг өөрчлөн байгуулагдаж буй хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьцаанд хөрвүүлэн ажлын 10 хоногийн дотор Улсын бүртгэлийн албанд бүртгүүлж, бүртгэлийн дүнг тус Хороонд мэдэгдэхийг “Сүлжээ” ХК /А.Зумаа/-д үүрэг болгосугай.

3.Энэхүү тогтоолын талаар Улсын бүртгэлийн албанд 10 хоногийн дотор мэдэгдэж тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар /Х.Бум-Эрдэнэ/-г даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

Хуулбар үнэн:
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

О.ГАНБАТ